



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/215

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Барилга байгууламжийн даатгал”-ын үйлчилгээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: Д.Эрдэнэбаатар Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга

Нарийн бичгийн

дарга: С.Наранбаатар Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Н.Жавхлан

“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Төлөвлөлт хөгжлийн хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Ц.Түмэннасан

Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

Б.Гантулга

Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Д.Эрдэнэбаатар/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /С.Наранбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН